

КАТОЛИК БА ҮНЭН АЛДРЫН ШАШНЫ ҮЗЭЛ НОМЛОЛ, ЗАН ҮЙЛ, ДҮРЭМ ЁС

О.Чимэг - МУИС.НШУС. Шашин судлалын тэнхим, доктор

Түлхүүр үг: христос шашин, сүсэг бишрэлийн илэрхийлэл, нийтлэг ба ялгаатай тал.

Товч агуулга: Энэ өгүүлэлд христос шашны католик, үнэн алдрын, протестант гэх гурван гол чиглэлээс хамгийн хуучны, “уламжлалт” хоёр чиглэл болох католик ба үнэн алдрын шашны “Сүсэг бишрэлийн бэлгэ тэмдэг” хэмээх Никей хотод болсон нийт христос шашинтны анхдугаар чуулган дээр баталж, Константинополь дахь хоёрдугаар чуулганаар баталгаажуулсан үзэл номлолоос гадна дээр дурдсан хоёр чиглэлийн үзэл номлол, зан үйл, дүрэм ёсны ялгаатай талыг авч үзсэн болно.

Дэлхийн гурван шашны нэг болох христос шашин нь м.э. I, II зуунд Ромын эзэнт гүрэнд үүсч, хожмоо дэлхийн олон улс оронд тархсан билээ. Христос шашин нь католик, үнэн алдрын \Orthodox\ ба протестант гэсэн үндсэн гурван чиглэлтэй. Үүнээс шинэчлэл /Реформац/ -ийн үр дүнд бий болсон протестант шашин нь маш олон сект буюу явцуу бүлэглэлд хуваагдаж, эрчимтэй үйл ажиллагаа явуулдаг \3-х.212\ Монголд газар аваад байгаа христос шашны урсгал чиглэлүүдийн ихэнх нь протестант шашинд хамаарч байгаа нь дээрхи онцлогтой нь холбоотой юм. Энэ асуудлыг хөндөлгүй энэ шашны “уламжлалт” хэлбэр болох католик ба үнэн алдрын ёсны үзэл номлол, зан үйл, дүрэм ёсны гол онцлог ба ялгаатай талыг толилуулахыг зорьлоо.

Христос шашин нь ээдрээтэй түүхийг туулж, хагарч бутарч, олон урсгал чиглэлийг төрүүлсэн. Анхны том хагарал 1054 онд гарч, албан ёсны сүм хийд нь католик ба үнэн алдрын ёс болж хуваагдсан байдаг. Үүнд улс төр, эдийн засаг, оюун санааны олон хүчин зүйл нөлөөлсөн боловч юуны өмнө Ромын эзэнт гүрний задрал түлхэц үзүүлсэн гэмээр байдаг. \6-х.509, 4,2\ . Хэдий тийм боловч энэ хоёр чиглэлийн аль аль нь “Сүсэг бишрэлийн бэлгэ тэмдэг” хэмээх 12 гишүүн бүхий христос шашинтны сүсэг бишрэлийн илэрхийлэл болсон гол үзэл номлолыг хүлээн зөвшөөрдөг. Уг баримт бичгийг 325 оны Никейн нийт христос шашинтны их чуулган дээр баталсан ба хожим 381 онд Константинополийн их чуулган дээр баталгаажуулсан. \4-х.553\ . Задралаас хойш католик сүм хийд дээрхи үзэл номлолд зарим нэг өөрчлөлт, тодотгол оруулсан байхаас гадна хагаралд хүргэсэн нэг шалтгаан нь 589 оны Толедийн чуулган дээр оруулсан өөрчлөлт байлаа \3-х.198\ . Тэр өөрчлөлтийг Зүүн Ромын сүм хийд хүлээн зөвшөөрсөнгүй. Энэ үйл явдлаас хойш баруун Ромын сүм хийд хэд хэдэн өөрчлөлт, тодотгол оруулсан ба эдгээр нь үнэн алдрын ёсноос ялгах бас нэг онцлог нь болдог. Никейн чуулган дээр баталсан 12 гишүүнт “Сүсэг бишрэлийн бэлгэ тэмдэг” дараах агуулгатай.

Сүсэг бишрэлийн бэлгэ тэмдэг /Символ веры/

1. Нэгдмэл Эцэг тэнгэрт итгэнэ. Тэрээр бүхнийг баригч бөгөөд Тэнгэр, газрыг бүтээсэн.

2. Нэгдмэл Эзэн Есүс Христэд итгэнэ. Тэрээр Эцэг тэнгэрээс \туяа нарнаас төрдөг шиг\ төрсөн хөвгүүн нь бөгөөд тиймээс ч түүнтэй нэг мөн чанартай.

3. Есүс Христ нь Ариун Сүнс ба охин Мариас хүний бие олж хувиран төрж бүх хүнийг аврахын тулд Газар Дэлхийд заларсан.

4. Есүс нь Понтий Пилатын үед цовдлуулж, хүний ёсоор зовж шаналж нас барсан. Энэ зовлон шаналлыг тэрээр бүх хүний өмнөөс, нүглийг нь цайруулах гэж өөртөө үүрсэн.

5-6. Христос нь 3 дахь өдрөө дахин амилж, тэнгэрт заларсан. Тэрээр хүч чадал, алдар гавъяаныхаа хувьд Эцэг тэнгэртэй адил тэгш.

7. Есүс Газар Дэлхий дээр хоёрдохоо заларч, амьд хүмүүс болон үхэгсдийг шүүнэ. Тэр үед үхэгсэд дахин амилна.

8. Ариун сүнсэнд итгэнэ. Ариун сүнс нь Эцэг тэнгэрээс үүдэлтэй бөгөөд түүнийг Эцэг тэнгэрийн адил шүтэх ёстой.

9. Нэгдмэл, Ариун, Чуулгант, Апостолын Сүм хийдэд итгэх ёстой. Үүнд:

- Ариун гэдэг нь Христ түүнийг ариусгасан, Эзэн тэнгэрийн адистэдтэй ,
- Чуулгант \Соборная\ гэдэг нь бүх үе, бүх улс түмний чөлөөт хувь хүмүүсээс

бүрдсэн,

- Апостолын гэдэг нь апостолуудаас залгамжилсан болохыг нь илтгэх ажээ.

10. Загалмайлах \шашинд орох\ нууц ёслолд итгэх ёстой.

11. Ирээдүйд үхэгсэд Дахин амилна.

12. Христ хоёрдохоо заларч, Аймшигт шүүх цааз болсны дараах

Мөнх амьдралд итгэх ёстой. \3, х. 189-190\

Дээрхи 12 гишүүний эхний 8 нь Эзэн тэнгэрийн гурвалсан чанар, Есүс Христ хүн болж хувиран төрсөн, нүглийг төлж цайруулсан ба дахин амилах тухай бол сүүлчийн 4 нь сүм, загалмайлуулж сүмийн эгнээнд орох ба мөнх амьдралын тухай байх ажээ \5, х.48\.

Католик ба үнэн алдрын шашны үзэл номлолын ялгаа

Баруун Ром католикийн болон үнэн алдрын сүм хийдийг өнөөг хүртэл ялган зааглаж буй үзэл номлолын зөрөө байх ажээ. Эдгээр ялгааны талаар С. А. Токаревын авч үзсэнээр өгүүлбэл \6, х.509\:

1. Католик сүм хийд нь Ариун сүнсийг Эцэг тэнгэр, хөвгүүн тэнгэрийн алинаас үүддэг \латинаар "filioque" хэмээх ба энэ нь "хүү" гэсэн үг дээр "ба" хэмээх холбоос үгийг нэмсэн үг\ гэж үздэг бол зүүн сүм хийд Ариун сүнсийг зөвхөн Эцэг тэнгэрээс үүсдэг гэж үздэг. Энэ зөрөөг католик ба үнэн алдрын шашин сүм хийдийн хамгийн гол, тэр битгий хэл цорын ганц эвлэршгүй зөрөө гэж үздэг.

2. Католик сүм хийд нь Христ, түүний эх ба гэгээнтнүүд Эзэн тэнгэрийн өмнө өөрт нь оногдсон үүргээ давуулан биелүүлсэн гавъяатай, тэр гавъяа нь сүм хийдийн мэдэлд байх "эрдэнэсийн сан" болж хуримтлагдаж байдаг гэж үзнэ. .

Энэ сангаасаа нүглийн өршөөл худалдах практик дундад зууны үед дэлгэрч нүглийн өршөөл болох индульгенцийг \латин хэлээр индульгенц нь өршөөл, хайр хишиг гэсэн утгатай үг ажээ\ паап ламын нэрийн өмнөөс олгодог байжээ.

3. Дээрхи практиктай холбоо бүхий ариусах орны \оросоор чистилище\ тухай номлол католик шашинд байдаг. Энэ номлолыг анх 1439 оны Флоренцийн их чуулган дээр албан ёсоор баталсан ба 1562 онд дахин баталгаажуулсан байна. Үүний дагуу нүгэл хийсэн хүмүүсийн сүнс галд шатан ариусах ба хожим нь диваажинд очно. Ариуслын оронд сүнсний байх хугацааг нас барагчийн ах дүү, хамаатан садан сүм хийдэд төлбөртэйгөөр ном уншуулах замаар багасгаж болно гэж үздэг.

Там, диваажингийн тухай сургаал, номлол ариусах орны тухай дээрхи ойлголттой холбоотой хөгжсөн аж.

4. Бүр IX зуунд Христийн эх Марь \оросоор Мария\ Ариун сүнснээс “бузаргүйгээр” хүүхэд олсон тухай сургаал байсан гэх ба 1864 онд \зарим мэдээгээр 1854\ энэ сургаал үзэл номлолын бүрэлдэхүүнд орж Христийн эх Марийн тахилга католик шашинд онцгой үүрэг гүйцэтгэх болсон байна. Католик шашныг ихэвчлэн шүтдэг Латин Америкийн кинонуудад бишгүй харагддаг шашны баяр ёслолын үед гэгээн Марийн баримлыг залж явах сүсэгтний цуваа үүний тодхон жишээ. 1950 онд Марь бие, сэтгэлээрээ тэнгэрт заларсан тухай үзэл номлол нэмэгдэж тэрээр Христтэй тэнцүү болжээ.

5. Сүсэг бишрэлийн асуудалд паап лам алдаа эндэгдэлгүй болох тухай 1870 онд баталсан номлол.

Католик шашинд паап ламыг Христийн газар дэлхий дээрхи төлөөлөгч буюу түүний шавь апостолуудын* залгамжлагч гэж үздэг. Паапын тусгай эрх мэдэл түүнийг Ромын анхны епископ** байсан Петрийн залгамжлагч, харин Пётр нь энэ эрх мэдлээ Христээс өөрөөс нь олж авсан гэж үздэгтэй холбоотой юм.

Католик ба үнэн алдрын шашны зан үйлийн ялгаа.

Аливаа шашны хурал номын үйл ажиллагаа үзэл төсөөллийн системтэй нь холбоотой байдаг. Хурал номын үйл ажиллагааны зорилго нь шашны үзэл номлолыг сүсэгтний ухамсарт бэхжүүлж, ертөнцийг үзэх шашны үзлийг төлөвшүүлэх явдал юм. Хурал номын үйл ажиллагаа тогтоосон дэгтэй байдаг.

Христос шашны гол хурлыг литургия гэх \грек хэлээр нийтээрээ үйлчлэн зүтгэх гэсэн утгатай үг\ бөгөөд эзэн тэнгэрт үйлчлэн зүтгэх агуулгатай ба католик шашинд месса \франц үг\, харин христос шашныг Византигаас уламжлан авч, грек нэр томъёог өргөн хэрэглэдэг Оросын үнэн алдрын шашинтнууд энэ хурлыг литургия гэдэг нэрээр нь өргөн хэрэглэхээс гадна оросчлоод обедня гэдэг. Хурлын дэг дээрхи хоёр ёсонд бас ялгаатай байх ажээ. \5, 49 х.\

Католик ба үнэн алдрын шашинд “нууц ёслол” \оросоор таинство\ хэмээх 7 зан үйл байх ба тэдгээрийг Есүс Христ тогтоосон гэж сүм хийд үздэг. “Нууц ёслол” гэхийн учир нь эдгээр зан үйлийн үед сүсэгтэн хүмүүс Эзэн тэнгэрийн үл харагдах адистэдийг хүртэж, тэр адистэд нь сүсэгтний оюун санаа, ёс суртахууныг өөрчилдөг тул нарийн, далд

утгатай гэсэн санааг илэрхийлдэгт оршино. Эдгээр зан үйл нь дараах 7 бөгөөд зарим нь литургийн бүрэлдэхүүнд ордог байна.

1. Загалмайлах \усан баталгаа\
2. Нанчид хүртээх
3. Сахил хүртэх
4. Нүглээ наминчлах
5. Тосон \миро\ түрхлэг
6. Гэр бүл болох
7. Өвчтнийг ариусгах \елейгээр ариусгах\ 5, х. 49\

Загалмайлах зан үйл буюу Монголд үйл ажиллагаа явуулж буй христос шашны зарим сүмийнхний нэрлэдэгчлэн “усан баталгаа” нь сүмийн эгнээнд орж байгааг бэлгэднэ. Аль ч шашинд сүм хийдийн эгнээнд багтан орж байгааг илэрхийлэх “ам өчиг”, түүнийг нь илэрхийлсэн зан үйл байдаг ба бурханы шашинд гончогсүм гурван эрдэнэд “Итгэл явуулж”, ислам шашинд “гэрчлэлийн” үг хэлэх замаар тухайн шашныг шүтэж байгаагаа илэрхийлдэг. Ус асгах эсвэл усанд дүрэх хэлбэртэй энэ зан үйлийн үр дүнд “хүн бие махбодийн нүгэлтэй амьдралаас хагацаж, түүнд оюун санааны ариун дор нээгддэг” хэмээн сүм хийд тайлбарладаг байна. Христос шашны үзэл номлолоор хүн анхны хүн болох Адам, Евагийн үр удам /8/ болох утгаараа тэдний “анхдагч нүгэлд” бузартаж, төрөлхийн нүгэлтэй төрдөг бөгөөд “усан баталгаа” нь тэр нүглийг нь “угаан” ариусгаж аврагдах бололцоогийг нь нээж өгдөг байна. Энэ зан үйлийн эх үүсвэр усны ариусгах чадварыг зан үйлдээ тусган хэрэглэж байсан христос шашин үүсэхээс өмнөх үеийн эртний ертөнцийн шашнуудаас улбаатай юм. \1\

Нанчид хүртээх \грекээр евхаристия\ . Католик ба үнэн алдрын ёсонд сүсэгтэнд талх, дарсаар нанчид хүртээх зан үйл нь литургид чухал байр суурь эзэлдэг. Христийн бие, цус хувилсан байдаг гэж үздэг. Нанчид хүртсэнээр сүсэгтнүүд Христийн биеийн хэсэг болох ажээ. \1\ Энэ зан үйлийг судлаачид тотемийнхоо мах, цуснаас хүртдэг тотемизмаас улбаатай зан үйл гэж үздэг бөгөөд Дж. Фрэзер зэрэг шашин судлалын сонгодгуудын цуглуулсан баялаг материал үүнийг нотолдог билээ. \ 7 \

Сахил хүртэх. Католик ба үнэн алдрын ёсонд сахил санваартан нь Эзэн тэнгэр ба хүний хоорондох зууч бөгөөд тэргүүн санваартан епископ \англиар bishop\ гар хүргэж “Ариун сүнсний” адистэдийг хүртээх замаар энэ эрх нь нээгддэг. Сахил санваарын 3 зэрэглэл байх ба тэргүүн зэрэг нь епископ, удаах нь пресвитер, дьякон хоёр юм.

Нүглээ наминчлах. Католик ба үнэн алдрын ёсонд лам хүнд нүглээ үнэнээр нь, ний нуугүй хэлж Эзэн тэнгэрийн өршөөлийг хүртдэг. Харин протестант шашинтнууд ламд хэлэхийг буруушаах ч хувь хүн Эзэн тэнгэрийн өмнө нүглээ хүлээж наминчлахыг чухалд үздэгийг дашрамд дурдая.

Тосон түрхлэг \миро түрхлэг\. Католик ба үнэн алдрын ёсонд энэ зан үйлийн замаар хүн тэнгэрийн адистэдийг хүртдэг гэж үзэх бөгөөд дух, нүд, чих болон биеийн бусад хэсэгт миро хэмээх анхилуун үнэртэй тос түрхдэг. Тосон түрхлэг нь элдэв ад зэтгэрийн хорлолоос хамгаалах утгатай бөгөөд муу юмыг анхилуун үнэртнээр үргээдэг байсан эрт үеийн хүн төрөлхтний заншлаас улбаатай. Эрт үед хаан ширээнд залахад энэ зан үйлийг хэрэглэдэг байжээ.

Гэр бүл болох зан үйл нь бусад “нууц ёслолоос” хожуу, ХҮГ зуунд тогтсон бөгөөд түүгээр гэр бүл бологсод “хүүхдээ төрүүлж, христос шашны ёсоор тэднийгээ хүмүүжүүлэх ариун, нэгдмэл санааны адистэдийг” хүртэх агуулгатай.

Өвчтнийг ариусгах. Мөргөл залбирлын үг хэлж, ариутгасан “елей” хэмээгдэх оливийн тосоор дух, хацар, уруул, цээж, гарыг түрхэх энэхүү зан үйл хүй нэгдлийн үеийн эмчилгээний домоос улбаатай. Үнэн алдрын ёсонд елей түрхэх зан үйлээр хүний бие, сэтгэлийн өвчнийг анагааж, наминчилж амжаагүй нүглээс нь чөлөөлж өгдөг хэмээн үздэг. Харин католик шашинд энэ зан үйл нь анагаах бус, харин нас барж буй хүнийг тайтгаруулж, захиас болох үүрэгтэй байдаг. \ 1 \

Дээрхи “нууц ёслолуудыг” үйлдэхэд “хууль ёсны” лам хүн оролцож, тодорхой дэг ёс, үг хэллэгийг баримтлах, сүсэгтнүүдийн хувьд бол сэтгэл зүйн бэлтгэлээ хангасан байх ёстой. Ийнхүү католик ба үнэн алдрын сүм хийд, лам санваартнууд Эзэн тэнгэр ба хүний хоорондох зууч болж тэдний оролцоогүйгээр “нууц ёслолууд” хүчин төгөлдөр байж чаддаггүй бөгөөд үүгээрээ Эзэн тэнгэртэй ямар ч зуучгүйгээр харьцах боломжтой гэж үздэг Шинэчлэлийн \Реформац\ үед үүссэн протестант шашнаас ялгаатай байх ажээ.

Католик сүм хийдийн сургаал ёсоор “нууц ёслол” хүчин төгөлдөр байх нь түүнийг гүйцэтгэж буй лам хүний хувийн зан чанараас үл хамаарна.

Католик ба үнэн алдрын шашны аль аль нь дээрхи зан үйлийг хүлээн зөвшөөрөх боловч католик шашинд заримынх нь утгыг арай өөрөөр тайлбарлахаас гадна дараах зүйлээр ялгаатай байдаг. Үүнд:

- . Загалмайлахдаа ус асгадаг \үнэн алдрын ёсонд ус руу дүрдэг\.
- . Нярай байхад нь бус, насанд хүрэхэд нь тосон түрхлэг үйлддэг.
- . Хар хүмүүст зөвхөн талхаар, лам хүмүүст талх ба дарсаар нанчид хүртээнэ . Гэхдээ хожмоо энэ зааг ялгаа өөрчлөгджээ.
- . Нанчид хүртээхэд эсгээгүй талх хэрэглэнэ.
- . Таван хуруугаараа загалмайлна \үнэн алдрын гол ёсонд гурван хуруугаараа , хуучин ёсонд хоёр хуруугаараа загалмайлдаг \
- . Зан үйлд латин хэл хэрэглэнэ \гэхдээ амьдрал практик дээр үндэсний хэл хэрэглэх явдлыг зөвшөөрдөг\
- . “Хуучин гэрээний” илүү олон номыг албан ёсоор хүлээн зөвшөөрдөг.

Католик ба үнэн алдрын шашны дүрэм ёсны ялгаа

Католик шашин нь үнэн алдрынхаас дараах дүрэм ёсны ялгаатай байдаг:

- . Бүх лам нар нь гэргийгүй \үнэн алдрын ёсонд зөвхөн санваартны нийгэмлэгийн гишүүн болж сүм хийддээ амьдардаг хүмүүс\
- . Санваартнууд нь сахил санваараа орхиж болдоггүй.

. Нийт католик шашинтны сүм хийд нэгдсэн удирдлагатай байх ба түүнийг нь паап лам нар тэргүүлдэг.

. Кардиналуудын байгууллага. Кардинал хэмээх нь голлох, тэргүүлэх гэсэн утгатай латин үг бөгөөд тэднийг паап лам консистори хэмээх кардиналуудын чуулганы зөвшөөрснөөр томилдог. Кардиналууд нь паап ламын шадар зөвлөгчид бөгөөд тэдний дотроос паап лам сонгогддог \1\.

. 21 их чуулганы шийдвэрийг хүлээн зөвшөөрдөг \үнэн алдрын ёсонд 7-г\

. Хар хүмүүс Библи уншиж, тайлбарлах явдал хориотой . Өнөө үед энэ хориг ийг чанд баримтлахаа больсон байна.

. Гэр бүлийг цуцалдаггүй г.м.

Католик шашны дээрхи онцлогууд нь олон зууны туршид сүсэгтэн олон түмэнд нөлөө үзүүлж, олон оронд улс төрийн асар их нөлөөтэй байж ирсэн тус шашны хүчирхэг зохион байгуулалтыг илтгэн харуулах ажгуу.

Паап ламын байгууллагаас нэг бус удаа зан үйлийн жижиг буулт хийж, зүүн зүгийн сүм хийдийг өөртөө захируулахыг оролдож байжээ. Гэвч зүүн зүгийн сүм хийдүүд бие даасан байдлаа хадгалсан байна. Харин түүхийн зарим үед холбоод \уния\ байгуулагдаж байсан нь 1439 онд Флоренцийнх, 1596 онд Брестийнх. Брестийн униат сүм гэхэд л Баруун Белорус ба Баруун Украины хүн амын хэсгийг хамарч XX зууны 40-өөд он хүртэл оршин тогтнож байв.\6, х.510\

Peculiarities of Dogma, Cult and Arrangement In Catholic and Orthodox Church

In this article except of the main dogmas of Catholic and Orthodox church, accepted on the first World Christians' Cathedral in Nicea and affirmed on the second one in Constantinople as a "Symbol of Faith", are considered some distinctions in dogma, cult and arrangement of Catholic and orthodox churches.

Ишлэл авсан бүтээлүүд

1. Атеистический словарь. М., 1984.
2. История средних веков. М., 2000.
3. Кулаков. А. Е. Религии мира. М., 1996.
4. Машкин Н. А. История древнего Рима. ОГИЗ., 1948.
5. Научный атеизм. М., 1974.
6. Токарев С. А. Религия в истории народов мира. М., 1986.
7. Фрээр Дж. Дж. Золотая ветвь. М., 1998.
8. Good News Bible. Australia, 2001.